



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
САНГИЙН ЗАХИРАЛ Х.ДОНДОГ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25 № 31/46

Өр авлагыг барагдуулах тухай


Шинжлэх ухаан, технологийн сангийн 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар тус сангаас санхүүжүүлсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын зээлийн эргэн төлөлттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх 25 ажилд 2001-2012 онд олгосон 375.5 сая төгрөгийн зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Шинжлэх ухаан технологийн хууль, Шинжлэх ухаан технологийн сангийн дүрмийг зөрчсөн, "Зэхэц" ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, санхүүжүүлэх, үр дүнг тооцох журмын 5.1-д "Хугацаа хэтэрсэн санхүүжилт болон тодорхой шалтгаанаар санхүүжилт эргэн төлөгдөөгүй төлбөрийг Сангийн удирдлага болон эргэн төлөгдөх хөрөнгийн асуудал хариуцсан ажилтан гэрээний дагуу гүйцэтгэгчид шаардлага тавьж төлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.
2. Дээрхи өр төлбөр болон төслийн байгууллагын авлага нь 868,0 сая төгрөг, нийт 1243,5 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийн зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн "Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн тухай" 15 дугаар зүйлийн 1-ийн 12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх" гэж заасныг үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Тус газрын нэтгэсэн тайлангаар 1243,5 сая төгрөгийн өр төлбөртэй бөгөөд үүнээс найдваргүй авлага болох 269,0 сая төгрөгийн материалыг бүрдүүлж, хуулийн байгууллагад өгч, холбогдох арга хэмжээг авч ажиллах хэрэгтэй.
2. Салбар байгууллагын өр авлага, өглөгийн үлдэгдлийг тайлант хугацаа бүрийн эцэст тооцоог нийлж актаар баталгаажуулж байх нь зүйтэй юм.

Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг гарган 2012 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт хариу ирүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Х.Дондог, ерөнхий нягтлан бодогч О.Наранбаатар нарт хариуцуулав.



АЛБАН ШААРДЛАГА

БИЧСЭН:  
Үндэсний аудитын газрын  
аудитор

УХА0122

Ж.Ядмаа



ХҮЛЭЭН АВСАН:  
Шинжлэх ухаан, технологийн  
сангийн захирал  
Х.Дондог  
Ерөнхий нягтлан бодогч

О.Наранбаатар

070073

## АЛБАН ШААРДЛАГЫН НОТЛОХ ЗҮЙЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС 2

### 1. Албан шаардлагын талаарх өрөнхий мэдээлэл


1	Аудитын нэр	Шинжлэх ухаан, технологийн сан
2	Аудитын код	УАГ-САГ/2013/13/СТА-ТС
3	Албан шаардлагын дугаар	
4	Албан шаардлага хариуцагчийн овог нэр, албан тушаал	Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Х.Дондог, Ерөнхий нягтлан бодогч О.Наранбаатар
5	Албан шаардлагын мөнгөн дүн тоо, үсгээр	1243.5 / Тэрбум хоёр зуун дэчин гурван мянга таван зуун мянган төгрөг /
6	Албан шаардлага бичсэн он, сар, өдөр	2013.03.25
7	Албан шаардлага тогтоосон ажилтын овог нэр, албан тушаал	Аудитор ..... А.К. Ядмаа/

### 2. Албан шаардлага бичих үндэслэлийн талаарх мэдээлэл

Алдаа, зөрчлийн товч утга	Өр авлагыг барагдуулах тухай	
Зөрчигдсөн хууль тогтоомж, заавар, журам, гэрээ хэлцлийн	Нэр	Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль
	Зүйл, заалт	Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 13.2 "Улсын төсвийн байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.
Албан шаардлага бичих үндэслэл болгосон хууль тогтоомж, журам, заавар, гэрээ хэлцлийн	Нэр	Төрийн аудитын тухай хууль
	Зүйл, заалт	"Төрийн аудитын тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага егөхөд баримтлах журам"-

### 3. Албан шаардлагын хууль эрх зүйн үндэслэлийн хяналт

.... дугаартай төрийн аудитын байгууллагын албан шаардлага бичих хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж, эвшигжсөн:

  
 /гарын үсэг/  
 2013.03.27. /овог, нэр/  
 огноо

Ерөнхий аудитороос өгсөн чиглэл:

**4. Албан шаардлага бичих алдаа, зэрчлийг нотлох зүйлийн хяналт**

.... дугаартай төрийн аудитын байгууллагын албан шаардлага бичих  
алдаа, зэрчлийг нотлох зүйлийн:

хангалттай  
найдвартай  
хүчин төгөлдөр  
үнэн зөв

боловхыг хянасан:

1-р хэлтсийн захирал, менежер  
/гарын үсэг/




/үзээр бичих /  
/үзээр бичих /  
/үзээр бичих /  
/үзээр бичих /

  
/овог, нэр/



С.Оюунгэрэл

Баталгаажуулсан:

САГ-ын захирал  
/гарын үсэг/

  
/огноо/

С.Энхзаяа

  
/овог, нэр/  
/огноо/